



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын “Тулга сувилал” ОНӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2026/15/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

Аудитор: Ч.Мөнхбаяр

Утас: 89275858

Цахим хаяг: [tseb.audit@gmail.com](mailto:tseb.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим илүүдэл: darhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 90

танил \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ШАРЫН ГОЛ СУМЫН  
"ТУЛГА СУВИЛАЛ" ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Ц.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Тулга сувилал" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Шарын гол сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 13,980.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 28-ний өдрийн 01-А/397 тоот захирамжаар 13 нэр төрлийн 6,538.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 16 нэр төрлийн 8,147.6 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг актлан үндсэн хөрөнгийн данснаас хасаж тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4529050297

## **Бусад асуудал**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 22 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 90.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.МӨНХБАЯР

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	92,342,954.74	37,358,288.81
1.1.2	Дансны авлага	8,058,557.00	3,984,409.50
1.1.6	Бараа материал	79,154,739.50	91,288,080.42
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>179,556,251.24</b>	<b>132,630,778.73</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	43,715,590.81	51,276,643.85
1.2.2	Биет бус хөрөнгө	362,956.14	799,956.14
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>44,078,546.95</b>	<b>52,076,599.99</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>223,634,798.19</b>	<b>184,707,378.72</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	10,182,685.34	80,903,036.91
2.1.1.2	Цалингийн өглөг		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>10,182,685.34</b>	<b>80,903,036.91</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>10,182,685.34</b>	<b>80,903,036.91</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	55,187,200.00	55,187,200.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,710,138.26	5,710,138.26
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	152,554,774.59	<b>42,907,003.55</b>
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>213,452,112.85</b>	<b>103,804,341.81</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>223,634,798.19</b>	<b>184,707,378.72</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>521,135,860.00</b>	<b>438,528,000.00</b>
2	Борлуулалтын өртөг		
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>521,135,860.00</b>	<b>438,528,000.00</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	-	
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	473,361,489.96	532,768,331.04
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		(15,407,440.00)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>47,774,370.04</b>	<b>(109,647,771.04)</b>
19	Орлогын татварын зардал		
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>47,774,370.04</b>	<b>(109,647,771.04)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>47,774,370.04</b>	<b>(109,647,771.04)</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
<b>24</b>	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
<b>25</b>	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
<b>26</b>	Бусад олз (гарз)		
<b>27</b>	<b>Орлогын нийт дүн</b>		-
<b>28</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>55,187,200.00</b>	<b>5,710,138.26</b>	<b>108,057,184.55</b>	<b>168,954,522.81</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(3,276,780.00)	(3,276,780.00)
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>			<b>104,780,404.55</b>	<b>104,780,404.55</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			47,774,370.04	<b>47,774,370.04</b>
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	<b>2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>55,187,200.00</b>	<b>5,710,138.26</b>	<b>152,554,774.59</b>	<b>213,452,112.85</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>55,187,200.00</b>	<b>5,710,138.26</b>	<b>152,554,774.59</b>	<b>213,452,112.85</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		(109,647,771.04)	<b>(109,647,771.04)</b>
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-			-
15	Зарласан ногдол ашиг				-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
17	<b>2025 оны 12 -р сары 31-ний үлдэгдэл</b>	<b>55,187,200.00</b>	<b>5,710,138.26</b>	<b>42,907,003.55</b>	<b>103,804,341.81</b>

## 32.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>521,135,860.00</b>	<b>426,548,000.00</b>
	Татаас, санхүүжилтийн орлого	521,135,860.00	426,548,000.00
	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>510,602,047.31</b>	<b>464,279,065.93</b>
	Ажиллагчдад төлсөн	299,283,163.00	343,211,678.95
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	36,070,217.00	39,998,653.92
	Бараа материал худалдан авахад төлсөн	141,248,667.31	81,068,733.06
	Ашиглалтын зардалд төлсөн	34,000,000.00	
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>10,533,812.69</b>	<b>(37,731,065.93)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(7,150,000.00)	<b>(17,253,600.00)</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,150,000.00	17,253,600.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>7,150,000.00</b>	<b>17,253,600.00</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>3,383,812.69</b>	<b>(54,984,665.93)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>88,959,142.05</b>	<b>92,342,954.74</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>92,342,954.74</b>	<b>37,358,288.81</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>						
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	м/төг	<b>521,135,860.00</b>	<b>438,528,000.00</b>	<b>438,528,000.00</b>	-	<b>100%</b>
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	521,135,860.00	438,528,000.00	438,528,000.00	-	100%
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	м/төг	<b>473,361,489.96</b>	548,175,771.04	<b>548,175,771.04</b>	-	<b>100%</b>
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг					
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	473,361,489.96	548,175,771.04	548,175,771.04	-	100%
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг					
<b>4</b>	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	м/төг	<b>47,774,370.04</b>	<b>(109,647,771.04)</b>	<b>(109,647,771.04)</b>	-	

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,253.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> нь Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 18.1, НББОУС-1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, НББОУС-7 “Мөнгөн гүйлгээний тайлан”, СТОУС 7 “Санхүүгийн хэрэглүүр, тодруулга”-т заасантай тус тус нийцээгүй тулд аудитын явцад дараах байдлаар залруулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн 17,253.6 мянган төгрөгийг дутуу тайлагнасныг мөнгөн гүйлгээний тайланд тусгаж тайлагнав.

Мөн аудитаар нийт 3,239.7 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч 1 зөвлөмж хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж<sup>2</sup>

#### 5.3.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт

Тайлант хугацаанд тус байгууллагын үндсэн хөрөнгөнд тооллого хийхэд 5 нэр төрлийн 6 ширхэг 3,239.7 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” Гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 18 дугаар зүйлийн 18.1-т заасныг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup> -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн 17,253.6 мянган төгрөгийг дутуу тайлагнасныг мөнгөн гүйлгээний тайланд тусгаж тайлагнав.	1	17,253.6	1	17,253.6			1	17,253.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>17,253.6</b>	<b>1</b>	<b>17,253.6</b>			<b>1</b>	<b>17,253.6</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд тус байгууллагын үндсэн хөрөнгөнд тооллого хийхэд 5 нэр төрлийн 6 ширхэг 3,239.7 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн байна.	1	3,239.7					1	3,239.7				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,239.7</b>					<b>1</b>	<b>3,239.7</b>			-	-



